

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07-р сарын 07-ны өдөр

№ 25/43

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дах заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/21 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн холбоотой этгээд болох “Монголиа Талент Нэтворк” ХХК-тай www.worki.mn платформыг ашиглан хүний нөөцийн бүрдүүлэлт хийх зорилгоор байгуулсан СЕ240223-01 дугаар Үйлчилгээ үзүүлэх гэрээний хугацаа дууссантай холбогдуулан Хавсралт 1-д заасан нөхцөлийн дагуу шинэчлэн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, Үйлчилгээ үзүүлэх гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

